

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30

E-mail: info@audit.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.БИЛГҮҮН ТАНАА

2020.02.21 № 06/597
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг сайжруулах чиглэлээр өгсөн нягтлан бодогчийг албан ёсоор томилох, НББ-ийн бодлогын баримт бичигт байгууллагын онцлог ажил гүйлгээг тодорхой тусгаж батлуулан, мөрдөх, ажил гүйлгээг аккрузль сууриар бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнах, тээврийн хэрэгслийн эзэмшлийг байгууллагын нэр дээр шилжүүлж бүртгүүлэх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-оос 2020 оны 02 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн яам нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1-3/388 дугаар бүхий албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Засгийн газрын 2019 оны 11 дүгээр тогтоолоор тус яамны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан байна.

Уг тогтоолд Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхэм зорилгыг “Монгол Улсад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлж, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны 5 тэргүүлэх чиглэлийг тодорхойлжээ.

Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх, бизнесийн эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн бодлого, хууль сахиулах стратеги, бодлого, төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр хангах замаар сайд, Засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, удирдлагын зохистой хэлбэр төлөвшүүлэх;
- удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар хууль сахиулах салбарын удирдлагын манлайллыг хангах, иргэн, байгууллагад үзүүлэх хууль зүйн үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх;
- хүний нөөцийн удирдлагын шилдэг арга барилыг хэрэгжүүлэх, хууль зүйн боловсрол, эрх зүйн сургалтын бодлогыг тодорхойлон төлөвшүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар оновчтой, чадварлаг бүтцийг хөгжүүлэх, сайдын эрхлэх ажлын хүрээний үйл ажиллагаанд Засгийн газраас төсөвлөсөн хөрөнгө, нөөцийг зохистойгоор хуваарилан зохицуулах;
- олон улсын болон гадаад улс орнуудын ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, олон улсын конвенцид нэгдэн орох, Монгол Улсаас бусад улс, орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах;
- Нээлттэй, ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль, дүрэм журмуудаас төсвийн хөрөнгөөр бараа, жил, үйлчилгээ худалдан авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйл “Гэрээ шууд байгуулах арга”-д “34.1.11.энэ хуулийн 10¹.2-т заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч үйлдвэрлэсэн бол”, мөн хуулийн 10 дугаар зүйл “Тендерт оролцогчдод давуу эрх олгох”-д “10¹-д Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах” гэсэн заалтууд тус тус нэмэгдсэн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 67 дугаар тушаалаар байгууллагын хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлуулсан ч өнөөг хүртэл холбогдох стандарт, хууль, журмын өөрчлөлтийг тусгаж, шинэчлэлт хийгээгүй байна.

Тус яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хууль зүй, дотоод хэргийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн байдлаарх нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоон, материаллаг байдлыг 46,955.6 мянган төгрөгөөр тодорхойлж, баталгаажуулсан болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь болоод хувь хэмжээнд өөрчлөлт оруулаагүй бөгөөд материаллаг байдлыг жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлын дүнг үндэслэн 204,017.0 мянган төгрөгөөр тооцлоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,202,913.1 мянган төгрөгөөр буюу 4.6 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	41,632.6	209,229.2	167,596.6
Урьдчилгаа	15,072.8		-15,072.8
Бараа материал	862,590.2	1,297,066.6	434,476.4
Үндсэн хөрөнгө	3,023,172.4	16,639,085.5	13,615,913.1
Нийт хөрөнгө	3,942,468.1	18,145,381.2	14,202,913.1
Өр төлбөр		175,455.5	175,455.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,942,468.1	17,969,925.7	14,027,457.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,942,468.1	18,145,381.2	14,202,913.1

Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөрийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн 209,229.1 мянган төгрөгийн үлдэгдлээс хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд 175,455.5 мянган төгрөг, ахмадын сангийн дансанд 33,773.6 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 434,476.4 мянган төгрөгөөр өссөн нь конторын барилгын гаднах 601,580.6 мянган төгрөгийн өртөг бүхий цахилгаан шугам сүлжээний байгууламжийг холбогдох байгууллагад шилжүүлэхээр эргэлтийн хөрөнгөнд бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 14,036,869.8 мянган төгрөгөөр өссөн нь конторын барилга 11,861,219.6 мянган төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 672,330.0 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж 626,617.6 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 792,946.3 мянган төгрөгөөр, бусад хөрөнгө 80,786.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Үүнээс хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 4,657,294.7 мянган төгрөгийн, урсгал санхүүжилтээр 419,305.3 мянган төгрөгийн, Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон ХЗДХЯ-ны хооронд байгуулсан гэрээний дагуу нэмэлт санхүүжилтээр 222,975.0 мянган төгрөгийн, давсан орлогоос 65,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, бусад байгууллагаас 8,639,797.4 мянган төгрөгийн барилга, тээврийн хэрэгсэл шилжүүлэн авсан байна.

ТӨБЗГ-аас 3 удаагийн тогтоол, 2 удаагийн албан бичгээр зөвшөөрөл олгосны дагуу нийт 672,571.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассанаас 465,890.7 мянган төгрөгийн хөрөнгийг харьяа байгууллагуудад шилжүүлж, 206,680.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

Тайлант онд өр төлбөр 175,455.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь гэрээгээр гүйцэтгүүлсэн 13 хөрөнгө оруулалт, арга хэмжээний ажлын барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 14,202,913.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд үндсэн хөрөнгө бэлтгэж, тайлант үеийн үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгад үндсэн хөрөнгө, шилжүүлж, акталсантай холбоотойгоор дахин үнэлгээний нөөц 2,636.3 мянган төгрөгөөр буурчээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан улсын төсвөөс 14,588,540.3 мянган төгрөгийг санхүүжүүлж, зарцуулахаар баталснаас урсгал зардалд 7,228,840.3 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 7,359,700.0 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 14,441,454.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 14,441,333.9 мянган төгрөгийг зарцуулан 121.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 14,441,333.9 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь хөрөнгийн зардал 125,730.6 мянган төгрөгөөр, урсгал зардал 21,475.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Урсгал зардлаас бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 17,079.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,043.4 мянган төгрөгөөр хэмнэсэн нь “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний хүрээнд зөвлөх үйлчилгээний тендерт бага үнийн саналаар ажил гүйцэтгүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 10 төсөл, арга хэмжээнд 7,359,700.0 төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 7,233,969.4 мянган төгрөгийг зарцуулсан нь мөн худалдан авах ажиллагааны журмын дагуу бага үнийн саналаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв:

ХЗДХЯ-ны нэмэлт төсөвт нийт 1,147,054.1 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдэж, 1,146,989.2 мянган төгрөгийг зарцуулан 64.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Нэмэлт төсвийн хүрээнд бүрүүлж, зарцуулсан арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

д/д	Орлогын утга	Дүн /мян.төг/
1	Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар “Хрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээний санхүүжилт”	29,550.0
2	НҮБ-ын Хүн амын сан “Женедерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр зохион байгуулах сургалт, туршлага судлах, орон нутагт ажиллах томилолтын зардал”	376,369.2
3	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр “Монгол Улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030-ийн хэрэгжилтийг дэжих ажлын хүрээнд судалгаа, зөвлөгөө, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах”	66,791.9
4	НҮБ-ын Хүүхдийн сан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажиллах дүрэм, гарын авлага, үлгэрчилсэн аргачлал боловсруулах, хэвлүүлэх зардал”	49,107.3
5	Герман Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүн орчинг баталгаажуулах төсөл хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний санхүүжилт	222,975.0
6	Засгийн Газрын 3 удаагийн тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас дамжуулан олгосон санхүүжилт	161,364.9
7	ХЗДХС-ын 2019.07.02 №1-1/3153 албан бичгээр Орчны бохирдлыг бууруулах, үндэсний хорооны дэд дарга, БОАЖ-ын сайд Н.Цэрэнбатад хүсэлт хүргүүлсний дагуу 6 аймгийн Цагдаагийн газрын цахилгааны зуухны ажлын санхүүжилт	155,830.9
8	Оюуны өмчийн газрын давсан орлогын хүрээнд авто машин авах	65,000.0
9	ЗГ-ын хурадааны 2019.05.22-ны 23-р тэмдэглэл, 2018 оны үйл ажиллагааны үр дүнгээр өндөр үнэлгээ авсан байгууллагын урамшуулал.	20,000.0
10	Тэмдэгний мөнгө /3 ширхэг/	64.9
Нийт дүн		1,147,054.1

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,453,150.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,230,909.2 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 71,206.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 151,034.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Конторын барилгын гадна цахилгаан шугам сүлжээний 601,580.6 мянган төгрөгийн байгууламжийг холбогдох байгууллагад шилжүүлэх шийдвэр гараагүй байхад данс бүртгэлээс хасаж, шууд зардлаар бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй 438,296.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэхдээ санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал зардлыг өсгөн давхар бичилт хийсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

3. Бусад байгууллагад 15,576.7 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлснийг үнэ төлбөргүй шилжүүлсэн зардлаар бус бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаар тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

4. Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн 13 компанид төлөх 175,455.5 мянган төгрөгийн өглөгийг харилцагч байгууллага тус бүрээр бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

5. Багаж техник хэрэгслийн болон урсгал засварын зардлаас нийт 3 удаагийн 71,206.5 мянган төгрөгийн худалдан авалтад харьцуулалтын журам мөрдөөгүй, 5 удаагийн худалдан авалтад шууд гэрээ байгуулахдаа техникийн тодорхойлолтыг бэлтгээгүй, гүйцэтгэчийг сонгохдоо ерөнхий нөхцөл, санхүүгийн, техникийн, туршлагын үзүүлэлтүүдийг үнэлж, магадалсан баримтгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 34 дүгээр зүйлийн 34.2-т “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана”, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ” Мөн урсгал засварын зардлаас уг хөрөнгийг бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж байх, уг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 151,034.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгснийг менежментийн захидлаар хүргүүллээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан ХЗДХЯ-ны төсвийн шууд захирагчийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитад хамруулж чадаагүй, дараагийн буюу Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нарийвчлан авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

- ХЗДХЯ-ны 2019 оны санхүүгийн тайланд 11,861,219.6 мянган төгрөгийн өртөг бүхий конторын барилгыг хүлээн авсан, улсын төсвөөс 3,861,219.6 мянган төгрөгийн, Хөрөнгө оруулалт, барилгын албанаас 8,000,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн,
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2011 онд батлуулсан боловч УСНББОУС, Сангийн сайдын болон бусад холбогдох дүрэм, журмын өөрчлөлт, шинэчлэлттэй уялдуулан тухай бүр нэмэлт өөрчлөлт хийгээгүй, үйл ажиллагааны зарим онцлогийг тусгаагүй байна.

Аудитын явцад анхаарал татахуйц дараах асуудлууд ажиглагдаа. Үүнд:

- Албан тушаалын болон албан ажлын суудлын авто машин хэрэглэх эрх бүхий 3 албан тушаалтанд хот дотор болон хөдөө ажлаар явах зориулалттай тус бүр 2 авто машин байна. Мөн албан тушаалын болон албан ажлын суудлын авто машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудад зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү цилиндрийн багтаамжтай авто машин хэрэглэж байна.

Энэ нь Засгийн газрын 2015 он 184 дүгээр тогтоолын 4.1-д "... хөдөө ажлын зориулалтаар хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 3501-4700 см³ автомашинтай байхыг зөвшөөрч, Улсын Их Хурлын шийдвэрээр байгуулдаг байгууллага, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, яам, Засгийн газрын агентлагийн хөдөө ажлын зориулалтаар ашиглаж байгаа автомашинуудыг Засгийн газрын автобаазад төвлөрүүлж, нэгдсэн журмаар гэрээний үндсэн дээр тээврийн үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах" гэж заасантай нийцэхгүй байна.

- Дотоод хяналтын үр нөлөө, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах хэд хэдэн асуудлууд ажиглагдлаа. Тухайлбал:
 - Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг тооцох үнэлгээ, судалгаа, харьцуулалт хийх нийт 23 гэрээт ажлын 186,200.0 мянган төгрөгийн санхүүжилтийг гэрээ дүгнэсэн актгүйгээр олгосон;
 - Харилцагч байгууллагуудтай хоорондын тооцоо нийлж хэвшээгүй;
 - ХЗДХС-ын тушаалаар харьяа байгууллагуудын 16 ажилтанд олгосон орон сууцны дэмжлэгийг Гүрт цамхаг ХХК, ЦЭЭБ ХХК-д шилжүүлснийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хууль зүй, дотоод хэргийн яам нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн мэдээллийг тухай бүр мэдээлээгүй, жилийн эцэст нийт дүнгээр нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр ГХЯ-аас 60,840.0 мянган төгрөгийн авто машиныг шилжүүлэн авч бүртгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг 80 хувьтай хэрэгжүүлж, 77,149.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тухайн жилийн батлагдсан төсвийн 50 гаруй хувийг эзэлдэг хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх, харьцуулалт судалгаа хийх зэрэг хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг хянах, хүлээн авч бүртгэл тайланд тусгах талаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т “Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Тухайн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, гүйцэтгэлд тавих хяналт сулрах, санхүүгийн тайлан холбогдох стандарт, журам, зааврын дагуу илэрхийлэгдэхгүй, материаллаг хэмжээний зөрчил үүсэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх, харьцуулалт судалгаа хийх зэрэг хөтөлбөр, арга хэмжээнд тавих дотоод хяналт, бүртгэлийн онцлогийг тодорхой тусгаж, мөрдлөг болгох.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ХЗДХЯ-ны 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1-4/881 дугаар албан бичгээр асуудлын бүртгэлийн хариуг ирүүлсэн болно.

3.2 Урьдчилж гарсан зардлын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Гэрээт ажлын санхүүжилт 122,000.0 мянган төгрөгийг урьдчилан олгож шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.6-д “Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг урьдчилж төлсөн урьдчилгаа болон урьдчилан төлсөн зардлуудыг урьдчилж төлсөн төлбөр/зардал/ гэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Гэрээт ажлын гүйцэтгэлд тавих хяналт алдагдаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, ашиглан шамшигдуулах;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж байх, гэрээний дагуу ажил, үйлчилгээний үнийг урьдчилан төлснийг урьдчилж төлсөн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ХЗДХЯ-ны 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1-4/881 дугаар албан бичгээр асуудлын бүртгэлийн хариуг ирүүлсэн болно.

3.3 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Ажил гүйлгээг аккруэл сууриар, харилцагч байгууллага бүрээр тооцоо үүсгэж бүртгээгүй, шууд зардлаар бүртгэсэн байна. Тайлант онд нийт ажил гүйлгээний 50 орчим хувийг шууд зардлаар бүртгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2.журналд бичих; 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг аккруэль сууриар бүртгэх зарчим алдагдаж, өглөг, авлагын журнал үнэн зөв хөтлөгдөхгүй байх, санхүүгийн тайланд авлага, өр төлбөр бүрэн илэрхийлэгдэхгүй байх;

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийг аккруэль сууриар хөтөлж, анхан шатны баримтыг үндэслэн тухай бүр өглөг, авлагын дэлгэрэнгүй журналыг хөтөлж байх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ХЗДХЯ-ны 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1-4/881 дугаар албан бичгээр асуудлын бүртгэлийн хариуг ирүүлсэн болно.

3.4 Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Урсгал зардлаас буюу багаж техник хэрэгслийн зардлаас 220,044.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т “Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн

нийлбэрээс бүрдэнэ”, 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааварт техник хэрэгслийн зардалд “... мөн албан хэрэгцээнд ашиглагдах компьютер, принтер, скайнер зэрэг тоног төхөөрөмжийг цөөн тоогоор худалдан авах зардлыг энэ ангилалд багтаана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах, үр ашиггүй хөрөнгө бэлтгэгдэх, холбогдох хууль, дүрэм журам зөрчигдөх;

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Урсгал зардлаас хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх, шаардлагатай тохиолдолд хөрөнгийн зардлаар төсөвт тусган батлуулж байх.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ХЗДХЯ-ны 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1-4/881 дугаар албан бичгээр асуудлын бүртгэлийн хариуг ирүүлсэн болно.

3.5 Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас олгох 29,034.3 мянган төгрөгийн гэрээт ажлын хөлсийг цалингийн зардлаас олгосон, зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулж гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-тай тус тус нийцэхгүй байна.

3.5.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах, зардлын ангилал буруу илэрхийлэгдэх;

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж байх, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийлгэх зөвшөөрөл авч байх.

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ХЗДХЯ-ны 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1-4/881 дугаар албан бичгээр асуудлын бүртгэлийн хариуг ирүүлсэн болно.

3.6 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.6.1. Илрүүлэлт:

Тус яамны санхүүгийн тайланд бүртгэлтэй 6 суудлын авто машины гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэн аваагүй байна.

Энэ нь Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 3.2-т “Өмчлөгч нь энэ журмын 3.1-д заасан шилжилт, хөдөлгөөнийг 7 хоногийн дотор хийлгэх үүрэгтэй” УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (а)-д “Үндсэн хөрөнгө гэдэг нь түрээслэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа ...” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.6.2. Эрсдэл:

